

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн  
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/12-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Сүхбаатар сум  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn  
Аудитор: Ж.Цогт  
Утас: 70362442 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт.....	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9-19
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9-10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..	10-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15-19
4. Аудитын тайлан.....	20-25
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....	20-21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22-23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	24-25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	25
5. Аудитын илрүүлэлт .....	25-28
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	29

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль, орчин аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль, орчин аялал жуулчлалын яам
ГХУССЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗЗНДНТУ	Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Т.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

2023.03.25 № СЭА-2023/12-НА-СТА-ТТЗ

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн зардлыг хөрөнгө оруулалтын бус урсгал зардалд тусган төлөвлөсөн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан, төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй худалдан авалтыг гүйцэтгэсэн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.24, 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 15.1.4, 15.2.3, Татварын ерөнхий хуулийн 28.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

СЭА-2023/12-НА-СТА-ТТЗ

4

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар 6,440,306.3 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 5,931,031.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 92.1 хувьтай тайлагнагдсан бөгөөд батлагдсан төсвийг 7.9 хувиар хэмнэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Сүхбаатар сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 21.1 хувийг буюу 1,253,295.2 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд, 28.2 хувийг буюу 1,674,745.4 мянган төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 15.9 хувийг буюу 944,349.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.


Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

СЭА-2023/12-НА-СТА-ТТЗ

5



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,031,428.1	2,279,577.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	607,761.5	1,223,871.7
33	АВЛАГА	1,040,360.6	966,040.4
35	БАРАА МАТЕРИАЛ	1,383,306.0	89,664.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	25,892,605.0	1,455,183.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	25,892,605.0	1,455,183.0
39200	Биет хөрөнгө	24,037,241.2	1,330,822.2
39300	Биет бус хөрөнгө	1,855,363.8	124,360.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	28,924,033.1	3,734,759.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	109,072.2	6,779.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	109,072.2	6,779.7
41300	Өглөг	109,072.2	6,779.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	28,814,960.9	3,727,980.2
51	Засгийн газрын хувь оролцоо	28,814,960.9	3,727,980.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	9,106,760.4	324,958.0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	9,106,760.4	324,958.0
51200	Хуримтлагдсан үр дүн	10,612,956.4	3,310,370.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,095,244.1	92,651.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	28,924,033.1	3,734,759.9

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,490,951.9	8,696,396.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,074,907.8	6,848,527.7
110	Орлогын албан татвар	866,396.9	6,348,318.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	866,396.9	6,348,318.5
113	Хөрөнгийн албан татвар	20,273.4	208,446.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	188,237.5	291,762.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,062,483.4	1,075,353.8
120	Нийтлэг татварын бус орлого	5,062,483.4	1,075,353.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,353,560.8	772,514.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,408,535.2	6,356,365.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,408,535.2	6,292,369.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,998,079.4	4,515,314.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,621,757.9	1,116,479.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,128,144.5	136,294.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,367,905.2	1,581,949.5
2104	Хангамж, бараа материалын зардал	263,838.7	59,565.4
2105	Нормативт зардал	213,752.7	700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	131,649.6	270,912.1
2107	Томилолт, зочны зардал	4,961.8	6,742.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	744,432.2	894,511.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,521,636.8	448,159.9
212	ТАТААС	-	264,978.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	410,455.8	1,512,077.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	63,995.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,082,416.7	2,340,030.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	891.6	1,214.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	248,423.0	20,279,465.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,834,885.3	(17,938,220.2)

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,980,075.6	-	24,980,075.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,770.7	-	4,770.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,984,846.2	-	24,984,846.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(4,770.7)	-	(4,770.7)
9	Тайлант үеийн үр дүн	3,834,885.3	-	3,834,885.3
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,814,960.9	-	28,814,960.9
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	28,814,960.9	-	28,814,960.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,880,234.5)	-	(1,880,234.5)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,934,726.4	-	26,934,726.4
19	Тайлант үеийн үр дүн	(17,938,220.2)	-	(17,938,220.2)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,727,980.2	-	3,727,980.2

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	14,869,995.1	8,218,801.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,074,907.8	6,848,527.7
110	Орлогын албан татвар	866,396.9	6,348,318.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	866,396.9	6,348,318.5
113	Хөрөнгийн албан татвар	20,273.4	208,446.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	188,237.5	291,762.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	160,045.0	173,205.4
1181	Газрын төлбөр	27,551.5	105,252.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	641.0	13,304.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	538,489.9	597,759.4
120	Нийтлэг татварын бус орлого	538,489.9	597,759.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,256,597.4	772,514.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,050,421.7	6,378,293.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,050,421.7	6,378,293.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,622,070.0	4,601,237.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,622,676.5	1,115,900.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,124,043.6	137,395.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,367,333.8	1,674,745.4
2104	Хангамж, бараа материалын зардал	159,407.9	59,085.4
2105	Нормативт зардал	322,514.4	700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	174,406.1	296,982.5
2107	Томилолт, зочны зардал	4,916.2	6,431.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	735,507.1	898,936.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,111,264.4	411,061.3
212	ТАТААС	-	264,978.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	428,351.7	1,512,077.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	819,573.4	1,840,508.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	595,237.3	1,091,120.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	595,237.3	1,091,120.6
2200	Дотоод эх үүсвэрээр	595,237.3	1,091,120.6

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(595,237.3)	(1,091,120.6)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(102,000.0)	(133,278.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	102,000.0	133,278.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	122,336.1	616,110.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	485,425.4	607,761.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	607,761.5	1,223,871.7

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,440,306.3	5,931,031.7	509,274.6	92.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,912,108.7	4,853,403.9	58,704.8	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,572,446.0	4,514,129.0	58,317.0	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,149,086.4	1,115,900.1	33,186.3	97.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,703.6	137,395.1	8,308.5	94.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,680,401.2	1,674,745.4	5,655.8	99.7
2104	Хангамж, бараа материалын зардал	60,608.4	59,085.4	1,523.0	97.5
2105	Нормативт зардал	758.8	700.0	58.8	92.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	324,329.4	324,172.3	157.1	100.0
2107	Томилолт, зочны зардал	6,439.8	6,431.4	8.4	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	884,350.7	877,298.2	7,052.5	99.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	320,767.7	318,400.9	2,366.8	99.3
212	ТАТААС	264,978.0	264,978.0	-	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	264,978.0	264,978.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,684.7	74,296.9	387.8	99.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,684.7	74,296.9	387.8	99.5
2133	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,328,197.6	944,349.8	383,847.8	71.1
2134	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,000.0	133,278.0	66,722.0	66.6
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,440,306.3	6,053,914.5	386,391.8	94.0
131001	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,061,985.3	5,894,008.1	167,977.2	97.2
131002	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	378,321.0	159,906.4	218,414.6	42.3
61	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	309,052.6	(309,052.6)	
62	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	430,835.5	(430,835.5)	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	234,788.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	115,207.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	113,198.1
2104	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,537.8
210402	Бараа үйлчилгээний бусад зардал	92,660.3
210403	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,009.4
2105	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,009.4
210502	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	119,581.0
2106	Дотоод эх үүсвэрээр	119,581.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	234,788.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	234,788.5

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сүхбаатар сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хууль тогтоомж төр засгийн бусад шийдвэрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн оновчтой бодлого зохицуулалтаар ханган төрийн албаны стандартыг бүрэн хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн болон сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, аймаг, сумын ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Аймгийн “Бүтээн байгуулалт, нийгмийн хөгжлийг дэмжих жил”-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайлагнах, үр дүнг тооцох,
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн хяналтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах,
- Эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулах,
- Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэнийг төлөвшүүлэх,
- Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх гэх мэт.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь оновчтой боловч хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзлээ. Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сүхбаатар сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,189,273.2 мянган төгрөгөөр буюу 87.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	607,761.5	1,223,871.7	616,110.2

Авлага	1,040,360.6	966,040.4	(74,320.2)
Бараа материал	1,383,305.9	89,664.8	(1,293,641.1)
Үндсэн хөрөнгө	25,892,605.0	1,455,183.0	(24,437,422.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>28,924,033.1</b>	<b>3,734,759.9</b>	<b>(25,189,273.2)</b>
Өр төлбөр	109,072.5	6,779.7	(102,292.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	28,814,960.8	3,727,980.2	(25,086,980.7)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>28,924,033.1</b>	<b>3,734,759.9</b>	<b>25,189,273.2</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансад бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,223,871.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 616,110.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	607,761.5	1,223,871.7	616,110.2
Төгрөг	607,761.5	1,223,871.7	616,110.2
Төрийн сангийн харилцах	607,471.5	1,223,871.7	616,400.2
Арилжааны банк дахь харилцах	290.0	-	(290.0)
<b>Дүн</b>	<b>607,761.5</b>	<b>1,223,871.7</b>	<b>616,110.2</b>

Эх сурвалж: Сүхбаатар сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлагнагдсан Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 793,036.2 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 280,978.2 мянган төгрөг, хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 149,857.3 мянган төгрөг тус тус байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 966,040.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 74,320.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	1,176.8	845.9	(330.9)
Татаас, санхүүжилтийн авлага	14,504.4	-	14,504.4
Байгууллагаас авах авлага	111,947.2	25,774.1	(86,173.1)
Хувь хүмүүсээс авах авлага	912,732.0	939,420.3	26,688.3
<b>Дүн</b>	<b>1,040,360.4</b>	<b>966,040.3</b>	<b>(74,320.1)</b>

Эх сурвалж: Сүхбаатар сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай /2013-2015 онуудад үүссэн итгэлийн зээл, татварын хөнгөлөлтийн авлага гэх мэт /10,628.5 мянган төгрөгийн

авлага байгаагаас орон нутгийн ерөнхий орлогын 3,795.3 мянган төгрөг, ЗДТГ-ын 6,833.2 мянган төгрөгийн авлагууд бүртгэлтэй байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 96.8 хувь буюу 935,875.4 мянган төгрөгийг ХХС-ийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

Насжилт өндөртэй /3-аас дээш жил/ ХХС-ийн зээлийн 635,559.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандаж 95 иргэний нийт 496,294.5 мянган төгрөгийн нэхэмжлэлийг хүргүүлж, 4 иргэнийг Шүүхийн шийдвэрийн дагуу эрэн сурвалжлах ажил хийгдэж байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Сумын ЗДТГ нь төлбөр тооцоог хянаагүйгээс цалин, ээлжийн амралтын олговрыг илүү олгосон гэх мэт албан хаагчидтай холбоотой 845.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,
- “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн БОАЖГ-аас Бэлчир бүсийн ойн ангид мод үржүүлгийн газар байгуулж, цахилгааны шугам татах ажлын урьдчилгаа 20,000.0 мянган төгрөгийг гэрээний дагуу “Мөнх номгон” ХХК-д шилжүүлсэн боловч үнийн өсөлттэй холбоотойгоор уг ажил хийгдээгүй байна.

**3.4.3 Бараа материал**

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 89,664.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,293,641.1 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл*

Үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>145,803.3</b>	<b>36,886.8</b>	<b>108,916.5</b>
Тусгай зориулалттай материал	135,396.7	36,886.8	(98,509.8)
Эм боох материал	10,406.6	-	(10,406.6)
<b>Хангамжийн материал</b>	<b>1,225,452.6</b>	<b>45,778.1</b>	<b>(1,179,674.6)</b>
Бичиг хэргийн материал	6,861.3	942.0	(5,919.3)
Аж ахуйн материал	623,149.1	33,073.2	(590,075.9)
Сэлбэг хэрэгсэл	2,929.1	1,914.0	(1,015.1)
Түлш, шатах тослох материал	4,354.0	-	(4,354.0)
Барилгын засварын материал	4,252.3	-	(4,252.3)
Бусад хангамжийн материал	582,403.9	16,848.9	(565,554.9)
<b>Мал амьтад</b>	<b>5,050.0</b>	<b>-</b>	<b>(5,050.0)</b>
<b>Дүн</b>	<b>1,383,305.9</b>	<b>89,664.8</b>	<b>(1,293,641.1)</b>

*Эх сурвалж: Сүхбаатар сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан*

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оныхоос 1,293,641.1 мянган төгрөгөөр буурсан нь 218,867.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан болон сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүд тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчид харьяалагдах болж, 1,334,286.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс ИТХ нь 5,894.2 мянган төгрөг, ЗДТГ нь 8,046.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй болон бөөн дүнгээр шивсэн байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,455,183.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 24,437,422.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>24,037,241.2</b>	<b>1,330,822.2</b>	<b>(22,706,419.0)</b>
Барилга, байгууламж, орон сууц	22,268,917.1	1,008,493.1	(21,260,424.0)
Авто-тээврийн хэрэгсэл	218,745.5	165,395.7	(53,349.7)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,861,994.6	153,403.6	(2,708,591.1)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,589,604.6	114,564.1	(1,475,040.5)
Бусад үндсэн хөрөнгө	1,382,805.8	297,912.6	(1,084,893.3)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,855,363.8</b>	<b>124,360.7</b>	<b>(1,731,003.1)</b>
Программ хангамж	83,739.3	2,682.5	(81,056.8)
Бусад биет бус хөрөнгө	1,805,229.8	123,567.9	(1,681,661.8)
<b>Дүн</b>	<b>25,892,605.0</b>	<b>1,455,183.0</b>	<b>(24,437,422.1)</b>

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Сүхбаатар сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос /анхны өртгөөр/ 29,178,234.7 мянган төгрөгөөр буурсан нь 6 дугаар цэцэрлэгийн их засвар болон төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж худалдан авсан 248,751.2 мянган төгрөг, 584,466.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан /380,581.9 мянган төгрөгийн ӨЭМТ-ийн барилгыг орлогод авсан, 86,955.2 мянган төгрөгийн өмнөх онд сумын ИТХ-ын тогтоолоор акталсан хөрөнгийг эргүүлэн орлогод авсан, БОАЖЯ-наас 52,228.2 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, аймгийн БОАЖГ-аас 4,478.8 мянган төгрөгийн компьютер/ зэрэг нийт 833,217.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 29,178,234.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр холбогдох ерөнхийлөн захирагчдад шилжүүлснээс голлон шалтгаалсан байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 6,779.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 102,292.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	1,570,648.4	425.0	(1,145.6)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,730.2	2,555.4	(1,174.7)
Байгууллагад төлөх өглөг	3,280.8	2,923.2	(357.6)
Хувь хүмүүст төлөх өглөг	100,490.5	876.0	(99,614.5)

/мянган төгрөгөөр/

Дүн	109,072.2	6,779.7	(102,292.5)
-----	-----------	---------	-------------

Эх сурвалж: Сүхбаатар сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд өмнөх оны орон нутгийн ерөнхий орлогын дансны 2013-2015 онуудад үүссэн 2,759.3 мянган төгрөг, ХХС-ийн 2015 оноос өмнөх 2,476.0 мянган төгрөг, ОНХС-ийн 563.4 мянган төгрөгийн болон тайлант онд шинээр үүссэн ИТХ-ын 681.8 мянган төгрөг, Ойн ангийн 185.5 мянган төгрөг, ЗДТГ-ын 113.6 мянган төгрөгийн өглөг тайлагнагдсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

Тайлант онд сумын ИТХ нь 681.8 мянган төгрөгийн, Ойн анги 185.5 мянган төгрөгийн, ЗДТГ нь 113.6 мянган төгрөгийн өглөг шинээр үүсгэсэн байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,727,980.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 25,086,980.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,106,760.4	324,958.0	(8,781,802.4)
<b>Хуримтлагдсан үр дүн</b>			
Өмнөх үеийн үр дүн	6,778,071.1	21,248,591.1	14,470,520.1
Тайлант үеийн үр дүн	3,834,885.3	(17,938,220.2)	(21,773,105.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,095,244.1	92,651.3	(9,002,592.8)
<b>Дүн</b>	<b>28,814,960.9</b>	<b>3,727,980.2</b>	<b>(25,086,980.7)</b>

Эх сурвалж: Сүхбаатар сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,727,980.2 мянган төгрөг болж 25,086,980.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

### 3.4.7 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **254,840.4** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.  
**Аудитын илрүүлэлт:**

**Төсвийн төвлөрүүлэн захирагч:**

- Тайлант оны 06 дугаар сард хийсэн төсвийн тодотголоор “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-т хуулийн дагуу санхүүжүүлэх гэрэлтүүлэг, нийтийн тээврийн санхүүжилтээс бусад буюу гэрэлт хөшөөний засвар, олон улсын худалдааны төвийн дээврийн засвар, кондейшн худалдан авах зэрэг хөрөнгө оруулалтын шинж чанартай зардлыг урсгал зардалд тусган 165,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 66,093.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

**Засаг даргын Тамгын газар:**

- Тус газрын 3 албан хаагчийг ээлжийн амралтаараа нутаг явсны зардалд 893.3 мянган төгрөг олгосон,
- Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хаагдаагүй болон хийсэн ажлын гүйцэтгэл бичигдээгүй томилолтын хуудас зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 576.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгож, бүртгэл тайланд тусгасан,
- Эвдрэл, гэмтлийг Өмч хамгаалах зөвлөлөөр тогтоогоогүй буюу зайлшгүй засвар хийлгэх эсэх техникийн комиссын дүгнэлтгүйгээр автомашины засвар үйлчилгээнд 12,001.5 мянган төгрөг зарцуулсан байна.

#### **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:**

- Сумын ИТХ-ын үйл ажиллагаа, ГХУССЗ-ийн үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах гэх үндэслэлээр видео шторк болон цахим нэвтрүүлэг /9 удаагийн/ бэлтгэхэд “Содон мэдрэмж” ХХК-д 15,800.0 мянган төгрөг шилжүүлсэн,
- Нутгийн удирдлагын 30 жилийн ойг тохиолдуулан баримтат кино хийлгэх зорилгоор “Визуал вишн” ХХК-д 5,000.0 мянган төгрөг шилжүүлж, гэрээт хугацаа дууссан боловч хүлээж аваагүй,
- Тогтоол, шийдвэрийн эмхэтгэл хийлгэх зорилгоор төсвийн хэмнэгдсэн зардлаас 8,000.0 мянган төгрөгийг “Сайн орших” ХХК-д 12 дугаар сарын 23-ны өдөр шилжүүлсэн,
- ИТХ-ын төлөөлөгчдийг Улаанбаатар хотод сургалтад хамруулахад 14,100.0 мянган төгрөг, “Орхоны давлагаа” ТББ-аар сургалт зохион байгуулуулж, 3,000.0 мянган төгрөг зэрэг нийт 17,100.0 мянган төгрөгийг сургалтад зарцуулсан,
- Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хаагдаагүй томилолтын хуудас болон хийсэн ажлын гүйцэтгэл бичигдээгүй зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 586.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгож, бүртгэл тайланд тусгасан,
- Бүх нийтийн амралтын өдрүүдээр ажилласан гэх үндэслэлээр жолоочийн тооцооны хуудас хөтөлж 649.2 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан боловч ажилласан цагийн бүртгэлээр нотлогдоогүй,
- Эвдрэл, гэмтлийг Өмч хамгаалах зөвлөлөөр тогтоогоогүй буюу зайлшгүй засвар хийлгэх эсэх техникийн комиссын дүгнэлтгүйгээр автомашины засвар үйлчилгээнд 1,234.4 мянган төгрөг зарцуулсан байна.

#### **Бэлчир бүсийн Ойн анги:**

- “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Мөнх номгон” ХХК-тай байгуулсан 20,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Дэд өртөөний барилга угсралтын ажил”-ыг ашиглалтад хүлээлгэн өгөөгүй байхад гүйцэтгэгч байгууллагад 4,000.0 мянган төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг бүрэн олгосон байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус СЭА-2023/12-НА-СТА-ТТЗ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Сүхбаатар сумын ИТХ-ын “2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 49 дүгээр тогтоолоор 6,395,569.6 мянган төгрөгийн татварын орлого, 273,096.4 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 7,287,099.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>6,395,569.6</b>	<b>7,001,733.0</b>	<b>606,193.4</b>	<b>109.5</b>
Хувь хүний орлогын албан татвар	5,051,210.6	5,632,317.3	581,106.7	111.5
Үйл ажиллагааны орлого	70,000.0	38,322.4	(31,677.6)	54.7
Хөрөнгийн орлого	505,200.0	386,515.3	(118,684.7)	76.5
Хөрөнгө борлуулсны орлого	286,000.0	9,696.6	(276,303.4)	3.4
Малын тоо толгойн албан татвар	20,479.0	17,137.9	(3,341.1)	83.7
Бууны албан татвар	5,500.0	6,326.0	826.0	115.0
Улсын тэмдэгтийн хураамж	81,000.0	108,734.8	27,734.8	134.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000.0	751.5	(248.5)	75.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	65,000.0	63,719.1	(1,280.9)	98.0
Газрын дуудлага худалдааны орлого	80,000.0	66,363.2	(13,636.8)	83.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	150.0	32.0	(118.0)	21.3
Байгалийн ургамал ашигласны төлбөр	30.0	42.5	42.5	141.7
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	13,230.4	13,230.4	
<b>Татварын бус орлого</b>	<b>273,096.4</b>	<b>285,366.5</b>	<b>12,270.1</b>	<b>104.5</b>
Хүү, торгуулийн орлого	243,096.4	220,810.1	(22,286.3)	90.8
Бусад орлого	30,000.0	64,556.4	34,556.4	215.2
<b>Нийт дүн</b>	<b>6,668,666.0</b>	<b>7,287,099.6</b>	<b>618,463.6</b>	<b>109.3</b>

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд ХХОАТ-ын орлого 581,106.7 мянган төгрөгөөр, бууны албан татвар 826.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 27,734.8 мянган төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөр 42.5 мянган төгрөгөөр, ус рашааны нөөц ашигласны төлбөр 13,230.4 мянган төгрөгөөр, бусад орлого 34,556.4 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөөгүй боловч гүйцэтгэлээр 13,230.4 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Үйл ажиллагааны орлого 31,677.6 мянган төгрөгөөр, хөрөнгийн орлого 118,684.7 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 276,303.4 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 3,341.1 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 248.5 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1,280.9 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 13,636.8 мянган төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 118.0 мянган төгрөгөөр, хүү, торгуулийн орлого 22,286.3 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

#### **Давж биелсэн орлогууд:**

- ✓ **ХХОАТ:** Цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотой,
- ✓ **Улсын тэмдэгтийн хураамж:** Төрөөс иргэдэд үйлчилдэг бүх төрлийн үйл ажиллагаа идэвхэжсэнээс шалтгаалсан,
- ✓ **Ус рашааны нөөц ашигласны төлбөр:** Орлогын төлөвлөгөөнд тусгагдаагүй 13,230.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

#### **Тасарсан орлогууд:**

- ✓ **Үйл ажиллагааны орлого:** Аж ахуй нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлогын эх үүсвэр буурснаас,
- ✓ **Хөрөнгийн орлого:** Орлогын төлөвлөлтийг үндэслэл муутай тооцсоноос тасарсан,
- ✓ **Хөрөнгө борлуулсны орлого:** Иргэдийн үл хөдлөх хөрөнгийн борлуулалт багассантай холбоотой,
- ✓ **Малын тоо толгойн албан татвар:** Татвар хураалтын ажил муу байгаатай холбоотой,
- ✓ **Ан, амьтны нөөц ашигласны төлбөр:** Иргэд ан, амьтан агнах зөвшөөрөл бага авснаас шалтгаалан,
- ✓ **Түгээмэл тархацтай ашигт малтмал:** Орлогын төлөвлөлтийг үндэслэл муутай тооцсоноос тасарсан,
- ✓ **Газрын дуудлага худалдаа:** 2020 оны 11 дүгээр сараас газрын даамал газрын төлбөр төвлөрүүлдэг байсныг татварын цахим төлбөрийн системд холбосонтой холбоотойгоор буурсан зэргээс голлон шалтгаалсан,
- ✓ **Хүү, торгуулийн орлого:** Орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөснөөс тасарсан байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 5,859,309.3 мянган төгрөгөөр тооцсон байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 27 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 6,759,866.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 46,000.0 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 423,694.8 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 537,726.3 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 202,000.0 мянган төгрөг нийт 7,969,287.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 55 дугаар тогтоолоор аймгийн 2022 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 91,200.0 мянган төгрөгөөр бууруулан 6,668,666.0 мянган

төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 46,000.0 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс 423,694.8 мянган төгрөг, ОНХС-аас олгох шилжүүлгийг 537,726.3 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 202,000.0 мянган төгрөг зэрэг нийт **7,878,087.1** мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, **6,440,306.3** мянган төгрөгийг зарцуулж, **1,437,780.8** мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр эцэслэн баталсан байна.

### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 7,287,039.6 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 537,726.3 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 54,004.6 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 105,901.8 мянган төгрөг зэрэг нийт **7,984,672.3** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **5,931,031.7** мянган төгрөг буюу 92.1 хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал **33,186.3** мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардал 8,308.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,655.7 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 1,523.0 мянган төгрөгөөр, нормативт зардал 58.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 157.1 мянган төгрөгөөр, томилолтын зардал 8.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 7,052.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 2,366.7 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 387.8 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 383,847.8 мянган төгрөг, эргэн төлөгдөх зээл 66,722.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Сумын хөрөнгө оруулалтаар нийт 19 төсөл, арга хэмжээнд 664,822.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 571,285.3 мянган төгрөгийн санхүүжилт олгон, 93,537.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 2 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй он дамжсанаас шалтгаалсан байна.

Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр нийт 6 төсөл, арга хэмжээнд 663,375.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 382,396.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 280,978.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 1 төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар ашиглалтад оруулах ажил оройтож он дамжсан, малын тоо толгойн албан татварын орлогоор хийх төсөл арга хэмжээнд иргэдийн санал авч зарцуулаагүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ЗДНХ-өөс 33,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргаас эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний зардалд 193,166.7 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 7,837.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 784.0 мянган төгрөг зэрэг нийт 234,788.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 20,537.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 92,660.3 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 2,009.4 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 119,581.0 мянган төгрөг зэрэг нийт **234,788.5** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үндсэн хөрөнгийг үнэн зөв тайлагнах, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг иж бүрэн хийж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/71 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 15,409,194.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 154,091.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан ЕБС-ууд, цэцэрлэгүүд, ӨЭМТ-үүд зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан тус тусын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал болох 6,356,365.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **63,563.7** мянган төгрөгөөр тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр СЭА-2023/12-НА-СТА-ТТЗ

авлага үүсгэхгүй ажиллах, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэлийг хүргүүлсэн байна.

Үүнээс Сүхбаатар сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- *Батлагдсан төсвийг 7.9 хувиар хэмнэсэн,*
- *Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтуудыг зөрчсөн нийт **38,793.3** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Сумын ЗДТГ нь 3 албан хаагчийг ээлжийн амралтаараа нутаг явсны зардалд 893.3 мянган төгрөг олгосон,
- Нутгийн удирдлагын 30 жилийн ойг тохиолдуулан баримтат кино хийлгэх зорилгоор “*Визуал вишн*” ХХК-д 5,000.0 мянган төгрөг шилжүүлсэн,
- Сумын ИТХ-ын үйл ажиллагаа, ГХУССЗ-ийн үйл ажиллааг иргэдэд сурталчлан таниулах зорилгоор видео шторк болон цахим нэвтрүүлгийг хийлгэхэд 15,800.0 мянган төгрөг шилжүүлсэн,
- ИТХ-ын төлөөлөгчдийг Улаанбаатар хотод сургалтад хамруулахад 14,100.0 мянган төгрөг, “Орхоны давлагаа” ТББ-аар сургалт зохион байгуулуулж, 3,000.0 мянган төгрөг зэрэг нийт 17,100.0 мянган төгрөгийг сургалтад зарцуулсан.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “*Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно*”, 12.1.2: “*... өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал*”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх “*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*”, 15.1.4: “*...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх*”, 15 дугаар зүйлийн 15.2 дахь “*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана*”, 15.2.3: “*сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	155	120	31	4
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	104	45	2
3	Засаг даргын Тамгын газар	151	90	40	21
7	Бэлчир бүсийн сум дундын ойн анги	151	151	-	-
	<b>Нийт дүн</b>	<b>608</b>	<b>465</b>	<b>116</b>	<b>27</b>

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 608 мэдээллээс 465 мэдээллийг хугацаанд нь, 116 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол огт мэдээлээгүй 27 мэдээлэл байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Сумын ИТХ-ын 2022 оны 49 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан сумын ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн санал авч, эрэмбэлэгдээгүй 20,479.0 мянган төгрөгийн 1 төсөл арга хэмжээг төлөвлөсөн нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3 дахь “Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга СЭА-2023/12-НА-СТА-ТТЗ

хэмжээг хэрэгжүүлнэ”, 4.3.2 дахь “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зураг төсөв, тооцоо судалгаа нь урьдчилан хийгдсэн төсөл, арга хэмжээг ОНХС-ийн төлөвлөгөөнд тусган, батлуулж байх зөвлөмж өгөв.

2. Сумын ОНХС-аас шинээр хэрэгжүүлэх 117,896.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгэлгүйгээр баталсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3 дахь “Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ”, 4.3.3 дахь “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх” заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөв.

3. Тагнуулын байгууллагын Аюулгүй байдлын шалгалтад хамруулж, зөвшөөрөл авалгүйгээр ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэж байсан Б.Сарантуяаг төрийн болон албаны нууц хариуцсан ажилтнаар ажиллуулж, 1,554.8 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам”-ын 1.2 дахь “Нууц хамгаалах ажилтнаар тагнуулын байгууллагын Аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн хүнийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон албаны нууц хариуцсан ажилтныг холбогдох хууль, журамд нийцүүлэн томилох зөвлөмж өгөв.

4. ЗДТГ нь шууд худалдан авах босго үнээс давсан 24,000.0 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэж, “Баялаг буян тулга” ХХК-иас худалдан авсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтын 2 дахь “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: бараа – 20.0 сая төгрөг, ажил – 20.0 сая төгрөг” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд босго үнийн журмыг баримтлах зөвлөмж өгөв.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн тодотгол хийсэн, өглөг авлага үүсгэсэн, үндэслэлгүйгээр хөрөнгө акталсан, анхан шатны баримтын бүрдүүлэлт, төлбөрийн цахим баримт, шилэн данстай холбоотой нийт 351,878.8 мянган төгрөгийн 9 зөрчилд албан шаардлага, зөвлөмж өгөгдсөнөөс өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй байна.

*Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	6	211,084.2	3	163,870.2	50.0
Зөвлөмж	3	140,794.6	2	40,811.8	66.6
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>351,878.8</b>	<b>5</b>	<b>204,682.0</b>	<b>55.5</b>

Өмнөх аудитаар өгсөн холбогдох анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж /худалдан авалт нь төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй болон бөөн дүнгээр шивээдсэн, автомашины засвар үйлчилгээг Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүйгээр гүйцэтгэсэн/ байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Өмнөх аудитаар өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд зөрчлүүдийг давтан гаргасан Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг

хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн сумын Санхүүгийн албаны дарга Э.Туул, ЗДТГ-ын нягтлан бодогч Б.Мөнхжаргал, ИТХ болон сан хариуцсан нягтлан бодогч Б.Болдцэцэг нарт **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг шалгаж амжаагүй тул Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчдын нэг удаагийн тэтгэмжийг аймгийн ЗДТГ-ын төсвийн мэргэжилтэн хянасан гэх үндэслэлээр зөрүүтэй тооцож олгох эрсдэл үүсэж байна. Иймээс аймгийн ЗДТГ-ын төсвийн мэргэжилтний хянаж, баталсан төсвийг гүйцэтгэлээр олгохдоо холбогдох баримт материалын бүрдлийг ханган, дахин хянаж олгосон эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй юм.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**Залруулаагүй алдаа :** / нийт 31,833.8 мянган төгрөг /

1. ЗДТГ нь 28,333.8 мянган төгрөгийн 11 төрлийн үндсэн хөрөнгийг “хасах” үнийн дүнгээр тайлагнасан, үндсэн хөрөнгийн дансанд бараа материал бүртгэсэн,

2. ИТХ нь 100 ширхэг хүндэт өргөмжлөл хийлгэхээр 2,000.0 мянган төгрөгийг, тараах материал хийлгэх зорилгоор 1,500.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлж хүлээн авсан боловч шууд зардалд тайлагнасан.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн нийт **262,608.0** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 6 албан тушаалтанд сахилгын хариуцлага ногдуулах албан шаардлага, зөвлөмж өгсөн.

#### 5.1 Албан шаардлага:

1. Тайлант оны 06 дугаар сард хийсэн төсвийн тодотголоор “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-г хуулийн дагуу санхүүжүүлэх гэрэлтүүлэг, нийтийн тээврийн санхүүжилтээс бусад буюу гэрэлт хөшөөний засвар, олон улсын худалдааны төвийн

дээврийн засвар, кондейшн худалдан авах зэрэг хөрөнгө оруулалтын шинж чанартай зардлыг хөрөнгө оруулалтын бус урсгал зардалд тусган **165,000.0** мянган төгрөгийн санхүүжилтийг шилжүүлснээс 66,093.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх “Хөрөнгө оруулалт гэж төсөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ”, 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2: “Төсвийн ...үнэн зөв байдлыг хангах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зардлын ангиллыг үнэн зөв төлөвлөх албан шаардлага хүргүүлэх.

2. Сумын ИТХ болон ЗДТГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс нийт **38,793.3** мянган төгрөгийн зөрчил гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.2: “... өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15 дугаар зүйлийн 15.2 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3: “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. **Үүнд:**

- ИТХ нь нутгийн удирдлагын 30 жилийн ойг тохиолдуулан баримтат кино хийлгэхэд 5,000.0 мянган төгрөг, ИТХ-ын болон ГХУССЗ-ийн үйл ажиллааг иргэдэд сурталчлан таниулах видео шторк, цахим нэвтрүүлэг хийлгэхэд 15,800.0 мянган төгрөг, төлөөлөгчдийг сургалтад хамруулахад 17,100.0 мянган төгрөг зэрэг нийт 37,900.0 мянган төгрөг,
- ЗДТГ нь албан хаагчийг ээлжийн амралтаараа нутаг явсны зардалд 893.3 мянган төгрөг.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

3. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс дараах байгууллага, хөтөлбөрүүдэд авлага, өр төлбөр үүсгэсэн, гэрээт ажил дуусаагүй байхад үлдэгдэл санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн нийт **21,826.8** мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь

“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...”, 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр гэрээний 5.1.Б дэх “Ажил бүрэн дуусаж захиалагчид хүлээлгэн өгснөөр 4,000,000 /дөрвөн сая/ төгрөгийг төлж, тооцоог бүрэн дуусгана” гэж заасныг зөрчсөн байна.

- Сумын ЗДТГ нь төлбөр тооцоог хянаагүйгээс ажилчидтай холбоотой 845.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,
- Бэлчир бүсийн сум дундын Ойн анги нь “Мод үржүүлгийн газар байгуулж, цахилгааны шугам татах” ажилд “Мөнх номгон” ХХК-д 20,000.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч гэрээт ажил хийгдэлгүйгээр авлага үүсгэсэн, үүнээс гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэж, захиалагчид хүлээлгэн өгөөгүй байхад үлдэгдэл санхүүжилт 4,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн,
- Сумын ИТХ нь 681.8 мянган төгрөгийн, Ойн анги нь 185.5 мянган төгрөгийн, ЗДТГ нь 113.6 мянган төгрөгийн ажиллагсадтай холбоотой өглөгүүдийг тайлант онд шинээр үүсгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, үүссэн авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэх.

4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс анхан шатны баримтын бүрдэлгүй нийт **15,047.1 мянган** төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл, тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Хаагдаагүй болон хийсэн ажлын гүйцэтгэл бичигдээгүй албан томилолтын хуудсаар ЗДТГ нь 576.0 мянган төгрөгийн, ИТХ нь 586.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон,
- Өмч хамгаалах зөвлөлөөр эдэлгээний хугацаа, зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын дүгнэлт гаргалгүйгээр автомашины засвар үйлчилгээнд ЗДТГ нь 12,001.5 мянган төгрөгийг, ИТХ нь 1,234.4 мянган төгрөгийг зарцуулсан,
- ИТХ нь жолоочийн тооцооны хуудсыг амралтын өдрүүдээр ажилласан байдлаар бичиж, нийт 649.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан боловч энэ нь ажилласан цагийн бүртгэлээр нотлогдохгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

5. Сумын ИТХ нь тогтоол, шийдвэрийн эмхэтгэл хийлгэх зорилгоор төсвийн хэмнэгдсэн зардлаас 12 дугаар сарын 23-ны өдөр **8,000.0 мянган** төгрөгийг “Сайн орших” ХХК-д шилжүүлж, авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, СЭА-2023/12-НА-СТА-ТТЗ

7 дугаар зүйлийн 7.7 дахь "... Төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд ... төсвийн зарцуулагдаагүй үлдээдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэгдсэн зардлыг төсөвт татан төвлөрүүлэх, авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

6. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй нийт **13,940.8 мянган төгрөгийн /ИТХ нь 5,894.2 мянган төгрөг, ЗДТГ нь 8,046.6 мянган төгрөг/** бараа материалын худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д "*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*" гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх албан шаардлага хүргүүлэх.

7. Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Гантулга, Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн дарга Ж.Эрдэнэцогт, "*Өргөн Сэлэнгэ үйлчилгээ*" ААТҮГ-ын захирал И.Чулуунболд нар нь албан үүргээ хангалтгүй гүйцэтгэн, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлж, санхүү төсвийн материаллаг хэмжээний зөрчил гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

### **5.3 Зөвлөмж**

#### **1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь "*Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна*", 8.1.5 дахь "*санхүүгийн тайлангийн тодруулга*" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ	1	28,333.8			1	28,333.8			1	28,333.8	1	28,333.8
ИТХ	1	3,500.0	1	3,500.0					1	3,500.0	1	3,500.0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>31,833.8</b>	<b>1</b>	<b>3,500.0</b>	<b>1</b>	<b>28,333.8</b>			<b>2</b>	<b>31,833.8</b>	<b>2</b>	<b>31,833.8</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ		165,000.0				165,000.0	1	-	1	1		
ЗДТГ		22,476.9				22,476.9			1	2		
ИТХ		54,945.6				54,945.6			1	2		
Ойн анги		20,185.5				20,185.5			1	1		
<b>Дүн</b>		<b>262,608.0</b>				<b>262,608.0</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>6</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
ТТЗ - 31 мэдээллийг хоцроож, 4 мэдээллийг мэдээлээгүй.	35					35		
ИТХ – 45 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй.	47					47		
ЗДТГ – 40 мэдээллийг хугацаа хоцроож, 21 мэдээллийг мэдээлээгүй.	61					61		
<b>Дүн</b>	<b>143</b>					<b>143</b>		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Иргэдийн санал авч, эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг ОНХС-д төлөвлөж, баталсан.	1	20,479.0					1	20,479.0
ОНХС-д зураг төсөв, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг баталсан.	1	117,896.0					1	117,896.0
Тагнуулын байгууллагын Аюулгүй байдлын шалгалтад хамруулж, зөвшөөрөл авалгүйгээр нууцын ажилтан томилж, ажиллуулсан	1	1,554.8					1	1,554.8
Худалдан авалтыг хууль, журам зөрчин зохион байгуулсан	1	24,000.0					1	24,000.0
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>163,929.8</b>					<b>4</b>	<b>163,929.8</b>
<b>Нийт дүн</b>	<b>147</b>	<b>163,929.8</b>					<b>143</b>	<b>163,929.8</b>